

ДОРНОД АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

**ГЭРЭЛТҮҮЛГИЙН БАРАА, МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ  
БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Төв замын гэрэлтүүлэг засвар, шинэчлэлт /Хэрлэн сум/  
Дугаар: ОНХС-2.4.13/2020

Дорнод аймаг, Хэрлэн сум

2020 он

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Төв замын гэрэлтүүлэг засвар, шинэчлэлт /Хэрлэн сум/” хийхэд шаардлагатай бараа, материал нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна

Үнийн саналыг **2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 цаг 00 минутад** энэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар  
Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сум, 10 дугаар баг  
Аймгийн Засаг даргын 3 дугаар байр, 210 тоот  
Утас: 7058-3058  
Цахим шуудан: [info@umch.dd.gov.mn](mailto:info@umch.dd.gov.mn)  
Цахим хуудас: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫ-ХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт															
ТОӨЗ 1.1	<p><b>Захиалагч:</b> Дорнод аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар  <b>Санхүүжилтийн эх үүсвэр:</b> Аймгийн орон нутгийн хөгжлийн сан  <b>Санхүүжих дүн:</b> 50,000,000 /тавин сая/ төгрөг  <b>Тендер шалгаруулалтын нэр:</b> “Төв замын гэрэлтүүлэг засвар, шинэчлэлт /Хэрлэн сум//”  <b>Тендер шалгаруулалтын дугаар:</b> ОНХС-2.4.13/2020</p>															
ТОӨЗ 1.1	<p>Тендер оролцогч нь туршлагын болон чадавхийн дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.</li> <li>- 2018, 2019 оны аль нэг жилд нь төсөвт өртгийн 30 хувиас багагүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна. Тухайн ажлын гэрээ, актыг үнийн саналд хавсарган ирүүлнэ.</li> <li>- Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онд гүйцэтгэсэн ажлын мэдээллийг хүснэгтийн дагуу гаргасан байна.</li> </ul> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th>№</th> <th>Төслийн нэр</th> <th>Гэрээний дүн</th> <th>Эхэлсэн, дууссан огноо</th> <th>Захиалагч байгууллага</th> </tr> </thead> <tbody> <tr> <td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td></tr> <tr> <td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td></tr> </tbody> </table>	№	Төслийн нэр	Гэрээний дүн	Эхэлсэн, дууссан огноо	Захиалагч байгууллага										
№	Төслийн нэр	Гэрээний дүн	Эхэлсэн, дууссан огноо	Захиалагч байгууллага												
ТОӨЗ 2.1	<p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр ирүүлэх ба оролцож байгаа тендерийн нэр, дугаарыг гаргацтай тэмдэглэнэ.</p> <p><b>Захиалагчийн хаяг:</b>  Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар  <b>Хаяг:</b> Дорнод аймаг, Хэрлэн сум, 10 дугаар баг  Аймгийн Засаг даргын 3 дугаар байр, 2 давхар, 210 тоот  <b>Утас:</b> 7058-3058  Цахим шуудан: info@umch.dd.gov.mn  Цахим хуудас: www.umch.dd.gov.mn, www.tender.gov.mn</p> <p><b>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</b>  <b>Огноо:</b> 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр  <b>Цаг:</b> 10 цаг 00 минут</p>															
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар  <b>Хаяг:</b> Дорнод аймаг, Хэрлэн сум, 10 дугаар баг  Аймгийн Засаг даргын 3 дугаар байр, 2 давхар, 210 тоот</p> <p><b>Огноо:</b> 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр  <b>Цаг:</b> 10 цаг 00 минут</p>															
ТОӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,</li> <li>- Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт,</li> <li>- Шүүхийн байгууллагын тодорхойлолт,</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт</li> <li>- Харилцагч банкинд хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай тодорхойлолт</li> </ul>															

	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй ба Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг шалгана.</li> <li>- Тендерт оролцогч нь өөрийн санал болгож буй бараа, материалын дэлгэрэнгүй үзүүлэлт бүхий техникийн тодорхойлолт, холбогдох бусад тайлбар, фото зургийг төрөл тус бүрээр гаргаж ирүүлнэ.</li> <li>- Холбогдох стандарт болон техникийн тодорхойлолтод заасан шаардлага, үзүүлэлтийг хангасныг нотлох үйлдвэрлэгчийн гэрчилгээ эсвэл гарал үүслийн гэрчилгээ</li> <li>- Баталгааг засварын хугацаа 1 жил байх тухай мэдэгдэл.</li> </ul>
<b>ТОӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь багцгүй.

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Барааны тодорхойлолт:** Санал болгож буй бараа, материал сэлбэг хэрэгсэл нь энэхүү үнийн санал авах баримт бичигт хавсаргасан техникийн тодорхойлолтоос гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - Хавсралтад заасан нэр төрөл, үзүүлэлттэй адил эсвэл түүнтэй дүйцэхүйц байна.
  - Монгол орны уур амьсгалд тохирсон, ашиглагдах боломжтой байна.
  - Тоног төхөөрөмжийн дээр үйлдлийн хэл нь англи эсвэл монгол байх бөгөөд ашиглалтын зааврыг монгол хэл дээр гаргасан байна.
- Стандарт:** Тухайн барааны Монгол улсын болон гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.
- Баглаа, боодол:** Тоног төхөөрөмж, бараа материал нь эвдэрч, гэмтэхээс хамгаалсан зориулалтын сав, баглаа боодолтой байна. Захиалагчийн заасан байршилд хүргэх хүртэл баглаа боодлыг тендерт шалгарсан гүйцэтгэгч хариуцах бөгөөд түүнтэй холбоотой зардал нь үнийн саналд тусгагдсан байна.
- Бараа хүргэх газар:** Дорнод аймгийн Хэрлэн сумын 1-р баг, "Гэрэл сэтгэмж" ОНӨААТҮГ.
- Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Барааг гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор нийлүүлэх бөгөөд дараах хүснэгтийн дагуу мэдээллийг бэлтгэн ирүүлнэ.

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
					Гэрээ байгуулсан өдөр	Гэрээ байгуулсан өдөрөөс хойш 30 хоногийн дотор	


## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Чойбалсан хотын төв замын гэрэлтүүлгийг шинэчлэх ажлын бараа, материал худалдан авна. Нийлүүлэх бараа материал холбогдох стандарт, чанарын шаардлага хангасан байна. Үүнд:


### ХУДАЛДАН АВАХ МАТЕРИАЛ, СЭЛБЭГИЙН ЖАГСААЛТ

№	материалын нэр	хэмжих нэгж	Тоо хэмжээ
0	1	2	3
1	Өдөр шенийн ялгавартай 380в, 3фаз, 100A, 2 тарифт тоолуур DTSD27	ш	15
2	Соронзон залгуур / 380v 95a пускатель CJX2 8011 /	ш	14
3	Цагийн релей / CHINT, Хүчдэл: 50HZ AC 230В, Ачаалал 3A-10A, 3KB, Удирдлагын программ 8-16, Ажиллах температур -40с- +40 с хэм /	ш	20
4	Клемм / металл, холболтын талбай нь 10 байна /	ш	200
5	Шитны хайрцаг / 400*600*180мм /	ш	10
6	Трансформатор 50W, 12V, 220-240с	ш	40
7	Трансформатор 400W, 12V, 220-240с	ш	20
8	Гэрэлтүүлгийн лед толгой 150W	ш	180
9	Гэрэлтүүлгийн лед толгой 50W	ш	180
10	Цахилгааны утас ВВГ 2*2.5 /1 боодол нь 100м/	боодол	4
11	Цахилгааны лент /1 боодолд 10ш UNIBEL, pvc insulating tape/	боодол	4
12	Бахь с13 том /tajima/	ш	4
13	Кусочик с13 том /tajima/	ш	4
14	Тестер / DIGITAL STANDARD MULTIMETERS UT50 /	ш	3
15	Лазер метр /100метр/	ш	1
16	Түрдэг метр /лед дэлгэцтэй/	ш	1
17	Ажлын бээлий /1 шуудайнд 600ш-тэй/	шуудай	1
18	Бензин АИ 92	л	400
19	Түлш ДТ	л	500
	дун		

**ӨДӨР ШӨНИЙН ЯЛГАВАРТАЙ 380В, 3ФАЗ, 100А-ИЙН 2 ТАРИФТ ТООЛУУР  
/DTSD27 /**






**СОРОНЗОН ЗАЛГУУР ПУСКАТЕЛЬ /380V 95A CJX2 8011/**




**ЦАГИЙН РЕЛЕЙ /CHINT/**

**ХҮЧДЭЛ: :50HZ AC 230В  
АЧААЛАЛ: 3A-10A 3КВ  
УДИРДЛАГЫН ПРОГРАММ: 8-16  
АЖИЛЛАХ ТЕМПЕРАТУР: -40С- +40 С ХЭМ**








КЛЕММ / МЕТАЛЛ, ХОЛБОЛТЫН ТАЛБАЙ НЬ 10 БАЙНА /




ШИТНЫХ ХАЙРЦАГ / 400\*600\*180мм /




ТРАНСФОРМАТОР /50W, 12V, 220-240C/




**ТРАНСФОРМАТОР / 400W, 12V, 220-240C /**




**ГЭРЭЛТҮҮЛГИЙН ТОЛГОЙ /150W LED/**





**ГЭРЭЛТҮҮЛГИЙН ТОЛГОЙ /50W LED/**



ЦАХИЛГААНЫ УТАС ВВГ 2\*2.5 /1 БООДОЛ НЬ 100М/



ЦАХИЛГААНЫ ЛЕНТ / 1 БООДОЛД 10Ш-ТЭЙ, Ф8см, -80с ХЭМД ТЭСВЭРТЭЙ,  
UNIBEL pvc insulating tape /




БАХЬ ТАЈИМА / C13 ТОМ /




КУСОЧИК ТАЈИМА / C13 ТОМ /



TECTEP / DIGITAL STANDARD MULTIMETERS UT50 /



ЛАЗЕР МЕТР /100МЕТР/



ТҮРДЭГ МЕТР /ЛЕД ДЭЛГЭЦТЭЙ/



БЭЭЛИЙ



## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

#### ДОРНОД АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧГИЙН ГАЗРЫН ДАРГА Ч.НЭРГҮЙ ТАНАА

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Үнийн саналын хүчинтэй хугацаа тендер нээсэн өдрөөс хойш 30 хоног байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>1 жил</b> байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>   | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>   | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br><br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнэ.   |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b>  | 9.1. Алданги оногдуулах хувь: 7 хоногт 0.5 хувь.<br><br>Алдангийн нийт дүн: 10 хувь  |

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>1</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>1</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]